



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/68/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он	Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас:70373089, 99023682 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: Ү.Батсүрэн Утас:99023682 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:99377479 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас:99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.4.3 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 127

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 8 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 58.6 хувиар өссөн байна.

4525026203

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.0 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,827,097.38	119,331,254.71
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,211,531.38	63,398,808.71
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,211,531.38	63,398,808.71
31210	Төгрөг	19,211,531.38	63,398,808.71
31211	Төрийн сангийн харилцах	19,211,531.38	63,398,808.71
35	БАРАА МАТЕРИАЛ	46,615,566.00	55,932,446.00
35100	Түүхий эд материал	926,980.00	232,530.00
35130	Эм боох материал	926,980.00	232,530.00
35400	Хангамжийн материал	45,688,586.00	55,699,916.00
35410	Бичиг хэргийн материал	19,200.00	19,300.00
35420	Аж ахуйн материал	40,819,831.00	390,980.00
35450	Барилгын засварын материал	36,800.00	597,500.00
35460	Хүнсний материал	4,651,155.00	8,563,225.00
35470	Бусад хангамжийн материал	161,600.00	46,128,911.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	438,927,418.60	475,840,739.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	438,927,418.60	475,840,739.54
39200	Биет хөрөнгө	433,203,418.60	470,116,739.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	416,383,428.00	416,383,428.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,509,568.87)	(42,432,696.63)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	44,437,630.00	68,982,230.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,648,395.60)	(30,805,176.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,099,228.75	36,099,228.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,660,248.87)	(19,680,810.47)
39209	Зам, гүүрийн байгууламж	9,865,600.54	15,865,600.54
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,997,455.35)	(2,433,263.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	27,015,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(110,000.00)
39217	Ном	1,233,200.00	1,233,200.00
39300	Биет бус хөрөнгө	5,724,000.00	5,724,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,724,000.00	5,724,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	504,754,515.98	595,171,994.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	504,754,515.98	595,171,994.25
51	Засгийн газрын хувь оролцоо	504,754,515.98	595,171,994.25
51100	Засгийн газрын оруулсан капитал	76,438,124.13	76,438,124.13
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	76,438,124.13	76,438,124.13
51200	Хуримтлагдсан үр дүн	312,360,760.97	402,778,239.24
51210	Өмнөх үеийн үр дүн	339,546,234.75	312,360,760.97
51220	Тайлант үеийн үр дүн	(27,185,473.78)	90,417,478.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	115,955,630.88	115,955,630.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	504,754,515.98	595,171,994.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	447,686,912.93	782,435,630.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	47,821,030.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	47,821,030.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	42,424,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	396,530.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,686,912.93	734,614,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	402,258,300.00	680,314,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	402,258,300.00	680,314,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,428,612.93	54,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,428,612.93	54,300,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	474,872,386.71	692,018,151.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,872,386.71	692,018,151.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	474,872,386.71	686,560,990.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,791,484.31	505,773,775.62
210101	Үндсэн цалин	220,747,678.82	327,525,317.76
210102	Нэмэгдэл	86,682,956.90	164,321,448.01
210104	Урамшуулал	11,360,848.59	13,927,009.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,963,289.15	62,991,327.05
210201	Тэтгэврийн даатгал	28,142,207.50	43,895,120.18
210202	Тэтгэмжийн даатгал	3,310,847.91	4,869,969.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,983,078.19	2,408,584.67
210204	Ажилгүйдлийн даатгал	619,817.40	2,279,615.69
210205	Эрүүл мэндийн даатгал	5,907,338.15	9,538,037.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,238,332.93	38,800,226.81
210301	Гэрэл, цахилгаан	5,067,521.04	4,203,870.36
210302	Түлш, халаалт	21,761,701.00	22,448,783.00
210303	Цэвэр, бохир ус	7,409,110.89	12,147,573.45
2104	Хангамж, бараа материалын зардал	105,600.00	-
210401	Бичиг хэрэг	105,600.00	-
2105	Нормативт зардал	39,897,842.20	38,462,330.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,220.00	85,000.00
210502	Хоол, хүнс	39,617,622.20	38,377,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,895,780.00	7,600,852.00
210604	Урсгал засвар	7,895,780.00	7,600,852.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	691,300.00	662,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	691,300.00	662,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,288,758.12	32,270,279.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,193,880.00	6,155,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,262,950.00	5,469,000.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,831,928.12	20,646,279.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,457,161.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,457,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,457,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	161.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	161.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(27,185,473.78)	90,417,478.27
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(27,185,473.78)	90,417,478.27

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/


Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	447,686,912.93	739,614,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,686,912.93	734,614,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	402,258,300.00	680,314,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	402,258,300.00	680,314,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,428,612.93	54,300,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,428,612.93	54,300,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	454,631,601.39	680,292,222.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454,631,601.39	680,292,222.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,631,601.39	674,835,061.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,791,484.31	505,773,775.62
210101	Үндсэн цалин	220,747,678.82	347,549,848.02
210102	Нэмэгдэл	86,682,956.90	144,296,917.75
210104	Урамшуулал	11,360,848.59	13,927,009.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,964,801.15	62,991,327.05
210201	Тэтгэврийн даатгал	28,142,207.50	43,895,120.18
210202	Тэтгэмжийн даатгал	3,310,847.91	4,869,969.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,983,078.19	2,408,584.67
210204	Ажилгүйдлийн даатгал	619,817.40	2,279,615.69
210205	Эрүүл мэндийн даатгал	5,908,850.15	9,538,037.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,238,332.93	38,076,836.21
210301	Гэрэл, цахилгаан	5,067,521.04	4,203,870.36
210302	Түлш, халаалт	21,761,701.00	22,448,783.00
210303	Цэвэр, бохир ус	7,409,110.89	11,424,182.85

2105	Нормативт зардал	39,714,843.00	42,289,400.00
210502	Хоол, хүнс	39,714,843.00	42,289,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,775,280.00	7,484,612.00
210604	Урсгал засвар	8,775,280.00	7,484,612.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	674,700.00	662,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	674,700.00	662,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,472,160.00	17,556,910.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,694,960.00	12,102,910.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,777,200.00	5,454,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	5,457,161.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	5,457,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5,457,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	161.19
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	161.19
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(6,944,688.46)	59,322,377.33
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,096,600.00	15,135,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,096,600.00	15,135,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,096,600.00	15,135,100.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	7,120,100.00
223001	Бусад хөрөнгө	0.00	8,015,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,096,600.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,096,600.00)	(15,135,100.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(10,041,288.46)	44,187,277.33
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,252,819.84	19,211,531.38
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,211,531.38	63,398,808.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	339,546,234.75	531,939,989.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	339,546,234.75	531,939,989.76
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчилөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			(27,185,473.78)	-27,185,473.78
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	312,360,760.97	504,754,515.98
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	312,360,760.97	504,754,515.98
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	312,360,760.97	504,754,515.98
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчилөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			90,417,478.27	90,417,478.27
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	402,778,239.24	595,171,994.25



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

дд	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	773,126,000.00	695,427,161.48	(77,698,838.52)	90.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	773,126,000.00	680,292,061.48	(92,833,938.52)	88.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,669,000.00	674,835,061.48	(92,833,938.52)	87.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	558,349,200.00	505,773,775.62	(52,575,424.38)	90.6
210101	Үндсэн цалин	368,866,800.00	347,549,848.02	(21,316,951.98)	94.2
210102	Нэмэгдэл	182,552,600.00	144,296,917.75	(38,255,682.25)	79.0
210104	Урамшуулал	6,929,800.00	13,927,009.85	6,997,209.85	201.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,246,700.00	62,991,327.05	(3,255,372.95)	95.1
210201	Тэтгэврийн даатгал	45,048,700.00	43,895,120.18	(1,153,579.82)	97.4
210202	Тэтгэмжийн даатгал	5,298,900.00	4,869,969.28	(428,930.72)	91.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,649,800.00	2,408,584.67	(241,215.33)	90.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,649,800.00	2,279,615.69	(370,184.31)	86.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,599,500.00	9,538,037.23	(1,061,462.77)	90.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,000,000.00	38,076,836.21	(14,923,163.79)	71.8
210301	Гэрэл, цахилгаан	13,572,000.00	4,203,870.36	(9,368,129.64)	31.0
210302	Түлш, халаалт	28,928,000.00	22,448,783.00	(6,479,217.00)	77.6
210303	Цэвэр, бохир ус	10,500,000.00	11,424,182.85	924,182.85	108.8
2105	Нормативт зардал	45,931,900.00	42,289,400.00	(3,642,500.00)	92.1
210502	Хоол, хүнс	45,931,900.00	42,289,400.00	(3,642,500.00)	92.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,500,000.00	7,484,612.00	(8,015,388.00)	48.3
210604	Урсгал засвар	15,500,000.00	7,484,612.00	(8,015,388.00)	48.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,942,400.00	662,200.00	(1,280,200.00)	34.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,942,400.00	662,200.00	(1,280,200.00)	34.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,698,800.00	17,556,910.60	(9,141,889.40)	65.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,241,800.00	12,102,910.60	(9,138,889.40)	57.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,457,000.00	5,454,000.00	(3,000.00)	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,457,000.00	5,457,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,457,000.00	5,457,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,457,000.00	5,457,000.00	-	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	15,135,100.00	15,135,100.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	15,135,100.00	15,135,100.00	-
222001	Тоног төхөөрөмж	-	7,120,100.00	7,120,100.00	-

223001	Бусад хөрөнгө	-	8,015,000.00	8,015,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	773,126,000.00	739,614,438.81	(33,511,561.19)	95.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	680,415,300.00	680,314,600.00	(100,700.00)	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	680,415,300.00	680,314,600.00	(100,700.00)	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,500,000.00	54,299,838.81	(14,200,161.19)	79.3
132001	Орон нутгийн төсвөөс	68,500,000.00	54,299,838.81	(14,200,161.19)	79.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,210,700.00	5,000,000.00	(19,210,700.00)	20.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	19,210,700.00		(19,210,700.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,211,531.38	19,211,531.38	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	63,398,808.71	63,398,808.71	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	20.00	(1.00)	95.2
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	13.00	(1.00)	92.9
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэг нь “Байгууллага, багш, асран хамгаалагчдын хоорондын харилцаа хамаарал, хамтын оролцоог нэмэгдүүлэх, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулах, хүүхдүүдийг тэгш хамруулан сургах, сурлагын чанарт ахиц амжилт гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус цэцэрлэг нь Шарын гол сумын “Өргөө”, “Хайрхан” багийн харьяа 2-5 насны хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг бүрэн хангаж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” ;

- Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90,417.4 мянган төгрөгөөр буюу 17.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,211.5	63,398.8	44,187.3
Авлага			-
Бараа материал	46,615.6	55,932.4	9,316.8
Үндсэн хөрөнгө	438,927.4	475,840.7	36,913.3

Нийт хөрөнгө	504,754.5	595,171.9	90,417.4
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	504,754.5	595,171.9	90,417.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	504,754.5	595,171.9	90,417.4

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 63,398.8 мянган төгрөг болж өмнөх оноос 44,187.3 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 55,932.4 мянган төгрөг болж 9,316.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 57,859.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 48,939.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 475,840.7 мянган төгрөг болж 36,913.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15,135.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 9,577.5 мянган төгрөгийн 7 ширхэг зөөврийн компьютер хүлээн авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар “Угаалгын тоног төхөөрөмж” төслийн хүрээнд 7,847.0 мянган төгрөгийн автомат аяга таваг угаагч, махны машин, дээжийн хөргөгч, хандиваар Шарын гол ХК-аас 25,000.0 мянган төгрөгийн эко модон тоглоом, бетонон талбай, нийт 42,424.5 мянган төгрөгийн хөрөнгийг Аймгийн засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01-А/450 захирамжаар үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, тайлант онд 20,646.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 595,172.0 мянган төгрөг болж 90,417.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 458,810.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 63,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 521,810.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 37,730.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 496,541.7 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 5,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 68,500.0 мянган төгрөг, нийт 565,041.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 8 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 183,873.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 680,415.3 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 19,210.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5,000.00 мянган төгрөг орон нутгийн төсвөөс 68,500.0 мянган төгрөг, нийт 773,126.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 680,314.6 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 19,211.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 54,300.0 мянган төгрөг, нийт 758,826.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 695,427.2 мянган төгрөг буюу 90.0 хувьтай зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 63,398.8 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	71801	Сургуулийн өмнөх боловсрол	773,126.0	695,427.2	77,698.8	90.0
1	80111	Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	68,500.0	54,299.8	14,200.2	79.3
2	80233	Хүүхэд хамгаалал	823.3	800.0	23.3	97.2
3	81605	Эрүүл мэндийг дэмжих	1,259.7	992.0	267.7	78.7
4	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	45,931.9	42,289.5	3,642.4	92.1
5	81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,237.0	2,147.4	89.6	96.0
6	80217	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	100.7	-	100.7	-
7	81823	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,259.3	335.0	924.3	26.6
8	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх	637,632.9	579,184.7	58,448.2	90.8
9	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	10,381.2	10,379.3	1.9	100.0
10	83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөр хувиарласан	5,000.0	4,999.5	0.5	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант зарлаагүй шууд гэрээ байгуулан ажилласан байна. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2024 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 5 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 475.263.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,505.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл,

төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрээс 65,029.0 мянган төгрөгийн 11 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Мөн тус цэцэрлэг нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 9,071.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, шилэн данстай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	9,071.3	2	9,071.3	67
Нийт дүн	3	9,071.3	2	9,071.3	67

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 52,702.4 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Хандиваар ирсэн 5,000.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд ангилал буруу бүртгэсэн,
2. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд хандиваар ирсэн 42,424.5 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан гэж бүртгэсэн.
3. Ашиглах жил оруулаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдлийг 5,277.9 мянган төгрөгөөр дутуу тооцсон.

